

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН “СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ-2050”, “ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР 2050”, “ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ 2021-2030” БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАЙЛАН**

2023.12.11

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүд болон хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, удирдлагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал.**

Хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

**Гурав. Танилцуулга**

3.1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэрэгжүүлэр бодлогын баримт бичгүдийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар нийт 113 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр **84,3% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** гэсэн үнэлгээтэй байна.

*Хэрэгжилтийн дэлгэрэнгүйг хавсралт 1,2,3-аас харах/*
*Хүснэгт-1*

Дд	Бодлогын баримт бичгийн нэр	Нийт арга хэмжээ	Үүнээс (хувиар)						Хувь
			100	90	70	50	30	х/б	
1.	“Стратеги төлөвлөгөө-2050	45	17	18	9	-	1	2	88,4%
2.	“Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2050”	37	14	8	9	2	2	-	83,1%
3.	“Хүний нөөцийн стратеги 2021-2030”	31	6	9	16	-	-	-	81,6%
<b>Нийт</b>		<b>113</b>	<b>37</b>	<b>35</b>	<b>34</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>84,3%</b>

3.2. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2023 онд нийт 3 удаа хуралдаж 4 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж 4 тогтоол гаргасан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь нийт 12 удаа хуралдан 15 тогтоол, шийдвэр гаргасан бөгөөд нийт тогтоол, шийдвэрийн биелэлт 99.6 хувьтай буюу **“Бүрэн хэрэгжсэн”** гэсэн үнэлгээтэй байна.

*Хэрэгжилтийн дэлгэрэнгүйг хавсралт 4,5-аас харах/*
*Хүснэгт-2*

Тогтоолын төрөл	Заалтын тоо	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
		100%	90%	70%	50%	30%		
1.Төлөөлөн удирдах зөвлөл	15	14	1	-	-	-	-	99,3%

2. Хувьцаа эзэмшигчдийн хурал	4	4	-	-	-	-	-	100%
	19	18	1	-	-	-	-	99,6%

Тогтоолыг агуулгаар нь авч үзвэл:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг томилох тухай-4;
2. Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай болон Компанийн 2023 оны батлагдсан төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай-3;
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх тухай болон Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тухай-2;
4. Гэрээ байгуулах эрх олгох тухай болон Эрх олгох тухай-2;
5. Компанийн Гүйцэтгэх захирлыг томилж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай болон Тогтоолд өөрчлөлт оруулах тухай-2;
6. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, ажилтнуудын цалин хөлсийг шинэчлэн батлах тухай болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг томилох тухай-2 тогтоолыг тус тус батлан гаргаж хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг томилогдсон албан тушаалтнууд /тооллогын комисс/ саналын хуудсаар Хувьцаа эзэмшигчдийн саналыг авч, танилцуулж, хурлын үйл ажиллагааг хэвийн явуулж ажилласан байна.

90%-тай 1 арга хэмжээ

**Тогтоолын заалт:** Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023.04.24-ны №07 тогтоолоор Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй “СӨРӨГ” санал дүгнэлт өгснийг зөвшөөрсүгэй.

**Хэрэгжилт:** Үндэсний аудитын газраас Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд албан шаардлага 9, залруулга 6, зөвлөмж 15, төлбөрийн акт 3, Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 2 дүгнэлт ирүүлснийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан. Үндэсний Аудитын газраас хийсэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн Аудитын талбарын ажил дуусч, “Төрийн аудитын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18-ын 1 дэх хэсэгт заасан дагуу тайлангийн төсөлд санал авахаар 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1421 тоот албан бичиг ирүүлсэн. Энэ дагуу дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч тайлан, түүний дүгнэлт хэсгүүдтэй газар, хэлтсийн дарга, инженерүүдэд нэг бүрчлэн танилцуулж зарим дүгнэлтэд хариу санал, тайлбаруудыг бэлтгүүлж, 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн “Union building” дэх оффисын хурлын танхимд төслийн гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн төлөөллийг байлцуулан уулзалт зохион байгуулж Аудитын ажлын хэсгийнхэнд танилцуулж хамтран ажилласан. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг холбогдох баримт, материалын хамт Үндэсний аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1591 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэрэгжүүлсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт,

бүртгэл, явц дундын төлбөрийн баталгаажуулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэлд Олон улсын хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэх ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн АГГ-2023/33 дугаартай гэрээг "Грант тронтон аудит" ХХК-тай байгуулан ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл тайлан зөвлөмжийг эцэслэн ирүүлэхээр ажиллаж байна.

**Зөвлөмж:** Олон улсын хөндлөнгийн аудитын ажиллах хугацаанд ажил, гүйлгээний талаар нотлох баримт, аудиторын ажлын баримт болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүрд шуурхай гарган өгч хамтран ажиллах.

### Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

Бодлогын баримт тус бүрээр дараахь дүгнэлт, зөвлөмжийнг хүргүүлж байна. Үүнд:

1. "ТТЗ" ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд хийх санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалтын дүнг тус тус үндэслэн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах эсэхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг үүрэг болгосон байгааг хэрэгжүүлэн аудитын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулах ажлыг зохион 12 дугаар сард багтаан баталгаажуулах нь зүйтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14,16 дахь заалтуудад заасан шаардлагыг хангаагүй учраас тендер дахин зарлагдахаар болсон нь ажлыг явцыг удаашруулж байгаа тул хугацааг зөв төлөвлөн, техник худалдаж авах ажиллагааг яаравчлах.

Шилжүүлэн ачих терминалын ажил 2023 оны 10 дугаар сард дууссан байхаар төлөвсөн нь зорилтот түвшинд хүрээгүй байна. Энэ нь 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б-23/01 тоот "Легал линк си би эй" ХХК-ийн Шилжүүлэн ачих терминалтай холбоотой учирч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх хууль зүйн товч дүгнэлт"-ийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг ШАТ төслийн ажил гүйцэтгэх гэрээг яаралтай байгуулан ажлыг эхлүүлэх.

Дээр заагдсан 70% тай 8 арга хэмжээг 2024 нарийвчлан төлөвлөж тухайн арга хэмжээ тус бүрийн дагуу хийгдэх ажлыг төлөвлөн гаргаж, төлөвлөгөөг батлуулан ажиллах нь зүйтэй байна.

2. "Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр 2050" хөтөлбөрийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Тээврийн удирдлагын газар заасан хугацаанд Засгийн газрын 206 дугаар тогтоолд заасны дагуу товч бөгөөд тодорхой ирүүлж хэвших;

Төсөл хөгжлийн газар, Тээврийн удирдлагын газрууд гэрээнд заасан хугацаанд дуусаагүй байгаа төслүүдийн гүйцэтгэлийг ерөнхий гүйцэтгэгчээс шаардах; *Тухайлбал үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн ч дээрх шалтгааны улмаас зүтгүүрүүд нийлүүлэгдээгүйгээс УБТЗ ХНН, Бодь интернэшнл ХХК-ийн зүтгүүрүүдээр тээвэрлэлт хийж, түрээсийн төлбөр төлж байна!*

Тээврийн удирдлагын газар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатыг 1 жилээр төлөвлөн төлөвлөгөө гарган батлуулж, ХШУДАА-нд 2024 оны 1 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэх;

3. Хүний нөөцийн стратеги 2021-2030" бодлогын баримт бичгийн хэрэгжилт хэвийн явагдаж байгаа хэдий ч бодлогын баримт бичгийн 5 зорилтын хүрээнд хийгдэх ажлууд нь 2022, 2023 онд хэрэгжиж дууссан байхаар байна. Мөн тухай арга хэмжээний зорилтод түвшинд хүрэхүйц тодорхой арга хэмжээ үе шаттайгаар төлөвлөж хийгээгүй байна.

Тэргүүлэх чиглэл 2 буюу "Байгууллагад ажилтнууд тасралтгүй суралцдаг системийг бий болгох, авьяас чадварын хөгжлийн ба карьерын менежментийг цогцоор нь хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд дараахь ажлуудыг эрчимжүүлэх. Үүнд:

- Компанийн сургалт хөгжлийн бодлогыг компанийн зорилго, зорилттой уялдуулан тодорхойлох, холбогдох дүрэм, журмуудыг боловсруулах, байнгын сайжруулалт хийх;
- Компанийн сургалт хөгжлийн үйл ажиллагааг сургалтын хөгжлийн 70/20/10-ийн загварын дагуу хөгжүүлэх, загварт нийцсэн хөтөлбөрийн боловсруулах;
- Ажилтнуудыг хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн хөтөлбөрүүд боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хөтөлбөр боловсруулах;
- Сургалтын хэрэгцээг хувь хүний, нэгжийн, байгууллагын чадамж нарийвчлан тодорхойлох чиглэлээр үндэслэлтэй судалгааг хийж, үр дүнг тооцон ажиллах;

Тэргүүлэх чиглэл 4 буюу “Компанийн үйл ажиллагааны өндөр гүйцэтгэл, эрчимтэй хөгжлийг хангах зөв манлайллыг төлөвшүүлэх” хүрээнд

- Манлайллыг байгууллагын бүх төвшинд буюу хувь хүний манлайлал, багийн манлайлал, байгууллагын манлайллыг хөгжүүлэх системийг бий болгох талаар тодорхой арга хэмжээг жилээр төлөвлөн гүйцэтгэх;
- Манлайллын судалгааг жилд 1 удаа тогтмол авч судалгааны үр дүнд үндэслэн ажиллах;
- Удирдах ажилтнуудын ур чадварын зөрүүг нөхөх, эрэлт хэрэгцээнд тулгуурласан манлайллын хөтөлбөрийг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу ажиллах;  
Нийт хэрэгжүүлэх 31 арга хэмжээнээс 16 арга хэмжээ 70%-тай байгаа нь тухайн бодлогын баримт бичгийн гүйцэтгэл зорилтод түвшинд хүрээгүй байгааг харуулж байна.

Мөн 2023-2024 онд Хүний нөөцийн дунд хугацааны стратеги боловсруулах талаар баримт бичигт тусгасаныг хэрэгжүүлэх.

Иймд тухай бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үр дүнтэй гүйцэтгэн чанаржуулан, дээрх зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрээр төлөвлөн, төлөвлөгөөг батлуулж ажиллах нь зүйтэй байна.

## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЛБА